

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан**

Аудитын код: ХӨА-2025/112/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мөрөн сум

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас:99389927 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа

Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com

Аудитор Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsGol@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/149
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГА Б. УРТНАСАН
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Зоонозын өвчин судлалын төв нь 2024 онд Улсын төсвөөс 854,977.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авахаас 854,977.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 853,588.7 мянган төгрөгийг зарцуулж 1,388.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 236,453.3 мянган төгрөгийн 6 алдаа зөрчлийг илрүүлснээс 232,004.1 мянган төгрөгийн 2 алдааг аудитын хугацаанд залруулж, 4,449.2 мянган төгрөгийг зөрчил 4 зөвлөмж өгсөн.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газартай байгуулсан 2024 оны гэрээний биелэлтийг 92.0 хувьтай дүгнэсэн байна.

6705021460

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн слон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага захиран эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь захиран эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЗБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,717,883.13	185,714,256.55
35	БАРАА МАТЕРИАЛ	110,717,883.13	185,714,256.55
351	Түүхий эд материал	66,088,829.03	130,985,777.45
35110	Тусгай зориулалттай материал	00.00	00.00
35130	Эм боох материал	66,088,829.03	130,985,777.45
354	Хангамжийн материал	44,629,054.10	54,728,479.10
35410	Бичиг хэргийн материал	1,835,950.00	3,451,750.00
35420	Аж ахуйн материал	7,885,850.00	7,674,550.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,687,120.00
35440	Түлш, шатах тослох материал	570,000.10	2,210,000.10
35450	Барилгын засварын материал	00.00	180,400.00
35470	Бусад хангамжийн материал	34,337,254.00	39,524,659.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	583,908,286.65	748,835,195.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	583,908,286.65	748,835,195.67
392	Биет хөрөнгө	542,458,286.65	707,385,195.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	398,706,501.00	398,706,501.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,379,654.20	-61,939,618.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,110,000.00	74,345,716.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-53,128,944.35	-60,311,182.61
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,993,423.73	505,320,891.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108,709,873.39	-149,615,259.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,398,163.50	13,908,163.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,717,661.56	-13,130,955.28
39209	Зам, гүүрийн байгууламж	1,234,000.00	1,187,200.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,047,668.08	-1,086,260.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,054,667.20	1,984,667.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,054,667.20	-1,984,667.20
393	Биет бус хөрөнгө	41,450,000.00	41,450,000.00
39301	Програм хангамж	1,090,000.00	1,090,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,090,000.00	-1,090,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	41,450,000.00	41,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	694,626,169.78	934,549,452.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,233,829.04	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,233,829.04	00.00
413	Өглөг	5,233,829.04	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,172,825.40	00.00
4136	Бусад өглөг	3,061,003.64	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,061,003.64	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	689,392,340.74	934,549,452.22
51	Засгийн газрын хувь оролцоо	689,392,340.74	934,549,452.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	365,177,414.00	365,177,414.00
51101	Өмч: - төрийн	365,177,414.00	365,177,414.00
512	Хуримтлагдсан үр дүн	144,183,285.45	389,345,608.93
51210	Өмнөх үеийн үр дүн	144,183,285.45	144,188,497.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	245,157,111.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	180,031,641.29	180,026,429.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	694,626,169.78	934,549,452.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	824,746,577.70	1,222,530,181.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	640,310,900.00	864,976,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	606,747,400.00	854,977,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	606,747,400.00	854,977,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,563,500.00	9,999,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,850,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	713,500.00	7,999,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	702,605,399.45	977,373,070.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	702,605,399.45	977,373,070.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	697,205,726.98	975,984,197.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	469,430,490.71	675,731,574.60
210101	Үндсэн цалин	266,344,933.19	350,344,093.30
210102	Нэмэгдэл	109,670,784.87	219,091,807.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,345,235.00	35,388,888.00
210104	Урамшуулал	69,069,537.65	70,906,785.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,526,400.00	91,381,095.97
210201	Тэтгэврийн даатгал	39,998,100.00	60,313,199.93
210202	Тэтгэмжийн даатгал	4,705,700.00	7,813,419.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,470,200.00	9,643,777.14
210204	Ажилгүйдлийн даатгал	941,100.00	1,089,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,411,300.00	12,520,799.77
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,900,722.91	37,412,677.64
210301	Гэрэл, цахилгаан	3,711,293.82	3,928,140.50
210302	Түлш, халаалт	30,998,239.64	31,869,662.64
210303	Цэвэр, бохир ус	1,191,189.45	1,614,874.50
2104	Хангамж, бараа материалын зардал	30,053,787.85	20,575,129.29
210401	Бичиг хэрэг	2,827,650.00	6,511,950.00
210402	Тээвэр, шатахуун	7,854,999.90	8,170,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	158,399.95	192,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	16,558,208.00	3,376,415.00
210408	Бараа материал акталсны зардал	2,654,530.00	2,324,464.29
2105	Нормативт зардал	38,771,287.89	66,526,714.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	38,771,287.89	66,526,714.36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,654,700.00	3,740,280.00
210604	Урсгал засвар	6,654,700.00	3,740,280.00
2107	Томилолт, зочны зардал	7,057,200.00	11,742,800.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	7,057,200.00	11,742,800.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,775,300.00	5,273,645.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,000.00	90,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	307,300.00	307,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,800.00	104,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	363,000.00	3,478,445.68
210807	Газрын төлбөр	124,200.00	124,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	95,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,035,837.62	63,600,279.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,950,000.00	963,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	30,085,837.62	62,637,229.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,399,672.47	1,388,873.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	00.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,099,672.47	1,388,873.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	122,141,178.25	245,157,111.48
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	56,874.76	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	56,874.76	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-56,874.76	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	122,084,303.49	245,157,111.48

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	640,310,900.00	864,976,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	640,310,900.00	864,976,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	606,747,400.00	854,977,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	606,747,400.00	854,977,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,563,500.00	9,999,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,850,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	713,500.00	7,999,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	640,310,900.00	864,976,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	640,310,900.00	864,976,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,911,227.53	863,587,726.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	467,257,665.31	677,904,400.00
210101	Үндсэн цалин	264,172,107.79	352,516,918.70
210102	Нэмэгдэл	109,670,784.87	219,091,807.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,345,235.00	35,388,888.00
210104	Урамшуулал	69,069,537.65	70,906,785.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,526,400.00	91,381,095.97
210201	Тэтгэврийн даатгал	39,998,100.00	60,313,199.93
210202	Тэтгэмжийн даатгал	4,705,700.00	7,813,419.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,470,200.00	9,643,777.14
210204	Ажилгүйдлийн даатгал	941,100.00	1,089,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,411,300.00	12,520,799.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,839,719.27	40,473,681.28
210301	Гэрэл, цахилгаан	3,711,293.82	3,928,140.50
210302	Түлш, халаалт	27,937,236.00	34,930,666.28
210303	Цэвэр, бохир ус	1,191,189.45	1,614,874.50
2104	Хангамж, бараа материалын зардал	11,981,599.95	15,671,000.00
210401	Бичиг хэрэг	2,774,000.00	2,774,200.00
210402	Тээвэр, шатахуун	7,360,000.00	9,810,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	158,399.95	192,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	970,700.00	1,825,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	718,500.00	1,069,500.00
2105	Нормативт зардал	7,930,593.00	11,869,304.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,305,793.00	9,326,804.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,624,800.00	2,542,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,651,750.00	8,355,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,208,900.00	2,185,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,962,000.00
210604	Урсгал засвар	6,442,850.00	4,207,300.00
2107	Томилолт, зочны зардал	7,057,200.00	11,742,800.00
210702	Дотоод албан томилолт	7,057,200.00	11,742,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,886,300.00	5,273,645.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,000.00	90,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	307,300.00	307,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,800.00	104,500.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	474,000.00	3,478,445.68
210807	Газрын төлбөр	124,200.00	124,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	95,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,780,000.00	916,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,780,000.00	916,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,399,672.47	1,388,873.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,099,672.47	1,388,873.07
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,177,414.00	181,047,091.29	21,083,531.96	567,308,037.25
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,177,414.00	181,047,091.29	21,083,531.96	567,308,037.25
Тайлант үеийн үр дүн			-134,409,976.73	-134,409,976.73
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,177,414.00	180,031,641.29	144,183,285.45	689,392,340.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,212.00	5,212.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,177,414.00	180,031,641.29	144,188,497.45	689,397,552.74
Тайлант үеийн үр дүн			245,157,111.48	245,157,111.48
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,177,414.00	180,026,429.29	389,345,608.93	934,549,452.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	856,694,300.00	854,977,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	856,694,300.00	854,977,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854,977,600.00	853,588,726.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	677,904,400.00	677,904,400.00
210101	Үндсэн цалин	363,295,100.00	352,516,918.70
210102	Нэмэгдэл	230,734,200.00	219,091,807.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,610,300.00	35,388,888.00
210104	Урамшуулал	48,264,800.00	70,906,785.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,529,600.00	91,381,095.97
210201	Тэтгэврийн даатгал	60,313,200.00	60,313,199.93
210202	Тэтгэмжийн даатгал	6,260,400.00	7,813,419.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,183,100.00	9,643,777.14

210204	Ажилгүйдлийн даатгал	1,252,100.00	1,089,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,520,800.00	12,520,799.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,598,200.00	40,473,681.28
210301	Гэрэл, цахилгаан	4,685,800.00	3,928,140.50
210302	Түлш, халаалт	34,757,700.00	34,930,666.28
210303	Цэвэр, бохир ус	2,154,700.00	1,614,874.50
2104	Хангамж, бараа материалын зардал	13,812,200.00	13,760,150.00
210401	Бичиг хэрэг	2,774,200.00	2,774,200.00
210402	Тээвэр, шатахуун	9,810,000.00	9,810,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	241,300.00	192,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	281,700.00	278,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	705,000.00	705,000.00
2105	Нормативт зардал	7,859,100.00	7,817,254.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,284,200.00	5,274,754.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,574,900.00	2,542,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,360,500.00	8,355,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,191,200.00	2,185,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,962,000.00	1,962,000.00
210604	Урсгал засвар	4,207,300.00	4,207,300.00
2107	Томилолт, зочны зардал	8,557,600.00	8,546,500.00
210702	Дотоод албан томилолт	8,557,600.00	8,546,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,439,400.00	4,433,845.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,000.00	90,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	168,200.00	168,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	307,300.00	307,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	104,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,478,500.00	3,478,445.68
210807	Газрын төлбөр	124,200.00	124,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	95,200.00	95,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	916,600.00	916,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	916,600.00	916,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1716700.00	1388873.07
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	1,388,873.07
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	1,388,873.07
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,716,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,716,700.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	856,694,300.00	854,977,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	856,694,300.00	854,977,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	856,694,300.00	854,977,600.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Нэмэл санхүүжилтийн тайлан:

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		9,999,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		9,999,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		9,999,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,910,850.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		1,546,350.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		364,500.00
2105	Нормативт зардал		4,052,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		4,052,050.00
2107	Томилолт, зочны зардал		3,196,300.00
210702	Дотоод албан томилолт		3,196,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		839,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		839,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		9,999,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		9,999,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		7,999,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 236,453.3 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчлийг илрүүлснээс 232,004.1 мянган төгрөгийн 2 алдааг аудитын хугацаанд залруулж, 4,449,2 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өглөө.

5.1 Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн тодруулгад 227,564.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг худалдан авснаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 “үнэн зөв байх” заалтад нийцэхгүй “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө дансанд бүртгэж залруулсан.
- Үр дүнгийн тайланд 4,440.0 мянган төгрөгийн бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, аж ахуйн материалын зардлыг бичиг хэргийн зардлаар тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалт “үнэн зөв байх;” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул холбогдох дансанд бичилт хийлгэж залруулга хийсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,449.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,792.5 мянган төгрөгөөр бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагаас төлөх НДШ-ийн зардлаас ҮЭ-ийн татвар 221.4 мянган төгрөг, Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж зардлаас санхүүгийн программын төлбөр 93.8 төгрөгийг нийт 315.2 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалт, Сангийн сайдын 2021 оны “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” 190 дүгээр тушаалаар батлагдсан заавартай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

1. Нягтлан бодох бүртгэлийн ажилтны урамшууллын талаар

Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны Б/23 дугаар захирамжаар Зоонозын өвчин судлалын төвийн даргад, ЗӨСТ-ийн даргын тушаалаар нярав, нягтлан бодогч нарт санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт авсан гэсэн шалгуураар 4,134.0 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2 заалт, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан журмын 5.1 заалтад заасан шалгуур үзүүлэлт, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 заалтад заасан “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн...”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1 заалтад “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;” мөнгөн

урамшуулал олгохоор заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохдоо аудитын тайланд бичигдсэн болон бусад хяналтын байгууллагаас илрүүлсэн алдаа, зөрчил, өр, авлага, мэдээ, тайлангийн хугацаа, чанар зэрэг үзүүлэлтийг харгалзаж үзэх.

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус эрүүл мэндийн төв www.shilendans.gov.mn цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15 гүйлгээ хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 10 шийдвэрийг мэдээлээгүй нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” заалт болон “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

4.Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Зоонозын өвчин судлалын төв нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын төсөвт ахмадын санг төлөвлөж тусгах, сан байгуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх, төлбөрийн актыг барагдуулах ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 - ны өдрийн дотор оруулж, баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн тодруулгад үнэ төлбөргүй ирсэн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийг худалдан авсанаар тайлагнасан	1	227,564.1			1	227,564.1	1	227,564.1		
Үр дүнгийн тайланд 4,440,000 төгрөгийн бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, аж ахуйн материалын зардлыг бичиг хэргийн зардлаар тайлагнасан	1	4,440.0			1	4,440.0	1	4,440.0		
Дүн	2	232,004.1			2	232,004.1	2	232,004.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засгийн газрын 2029 оны 5-р тогтоолд заасан урамшууллын хэмжээг хэтрүүлж олгосон.	1	4,134.0					1	4,134.0
Зардлын зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна.	1	315.2					1	315.2
Дүн	2	4,449.2					2	4,449.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15 мэдээлэл оруулаагүй, хөрөнгө зарцуулахтай холбоотой 10 тушаал байршуулаагүй.	1	0,0					1	0,0
Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлээгүй ахмадын сан байгуулаагүй байна.	1	0.0					1	0.0
Дүн	2	0,0					2	0,0